



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 11 өдөр


Дугаар 1/447

Ховд

Цол олгох тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Тулгар төрийн 2230, 2231, Их Монгол улс байгуулагдсаны 815, 816, Ардын хувьсгалын 100, 101, Ховд аймгийн 90, 91 жилийн ойн баяр наадмын Үндэсний сурын харвааны эрэгтэй төрөлд 40 сумнаас 36 онож түрүүлсэн Дуут сумын харьяат Мөнгөнболдын Галбадрахад "Аймгийн мэргэн" цол, 40 сумнаас 32 онож дэд байр эзэлсэн Жаргалант сумын харьяат Ганболдын Ганзоригт "Аймгийн гарамгай харваач" цол, 40 сумнаас 32 онож 4 дүгээр байр эзэлсэн Жаргалант сумын харьяат Мөнгөнхуягийн Бумбаярт "Аймгийн онч харваач" цол тус тус олгосугай.



Б.ДҮГЭРЖАВ